

## ҮНЭТ ЦААСНЫ ТООЦООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмаар арилжаа эрхлэх байгууллага дээр арилжаалагдсан үнэт цаасны төлбөр тооцоог “Арилжааны төлбөр тооцоо” ХХК /цаашид Тооцооны байгууллага гэх/ гүйцэтгэхтэй холбоотой Тооцооны байгууллага болон Төлбөр гүйцэтгэгч банк /цаашид “ТГБ” гэх/, Төвлөрсөн хадгаламжийн байгууллага, үнэт цаасны компани /цаашид “ҮЦК” гэх/-ийн хооронд үүсэх эрх, үүргийн харилцаа болон төлбөр тооцоог гүйцэтгэх хугацааг зохицуулахад оршино.

1.2 Тооцооны байгууллагатай үнэт цаасны арилжааны мөнгөн болон үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэх гэрээ байгуулан оролцож буй этгээд энэхүү журмыг нэгэн адил мөрдөнө.

1.3 Энэхүү харилцаанд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагааны ерөнхий журам” болон энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.4 Үнэт цаасны төлбөр тооцоог T+1 горимоор хэрэгжүүлнэ.

1.5 Энэхүү журмын дагуу Тооцооны байгууллагын ажил үйлчилгээтэй холбоотойгоор Тооцооны байгууллагаас шаардлагатай шинэ маягтыг гаргаж, түүнд нэмэлт өөрчлөлтийг оруулж болно.

#### Хоёр. Нэр томъёоны тайлбар

2.1 Энэхүү журамд орсон нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно:

2.1.1 “Арилжааны өдөр” гэж арилжаа эрхлэх байгууллагын арилжаа явагдах өдрийг;

2.1.2 “Арилжаа” гэж арилжаа эрхлэх байгууллагын электрон арилжааны системээр гүйцэтгэгдсэн үнэт цаас худалдах, худалдан авах хэлцлийг;

2.1.3 “Тооцооны данс” гэж Тооцооны байгууллагын тухайн этгээдийн нэр дээр бүртгэлтэй дансыг;

2.1.4 “Тооцооны гишүүн” гэж Тооцооны байгууллагын шаардлага, шалгуурыг хангасан хуулийн этгээд бөгөөд дараах байдлаар ангилагдана;

2.1.4.1 “Тооцооны шууд гишүүн” гэж арилжаа эрхлэх байгууллагын гишүүнчлэлтэй бөгөөд зөвхөн өөрийн харилцагчдын төлбөр гүйцэтгэх үүрэг бүхий зохицуулалттай этгээдийг;

2.1.4.2 “Тооцооны ерөнхий гишүүн” гэж тооцооны эрхгүй гишүүний харилцагчдын төлбөр гүйцэтгэх үүрэг бүхий Тооцооны байгууллагын гишүүнийг;

2.1.7 “Онцгой нөхцөл байдал үүсэх” гэж үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 87 –р зүйлд заасан нөхцөл үүсэхийг;

2.1.8 “ҮЦК” гэж Санхүүгийн зохицуулах хорооноос зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан үнэт цаасны компанийг;

2.1.9 “Төлбөр гүйцэтгэх банк” гэж Монголбанкнаас мөнгөн хөрөнгийн төлбөр гүйцэтгэх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй Тооцооны байгууллагын шалгуурыг хангасан арилжааны банкиг;

2.1.10 “Төлбөр гүйцэтгэх өдөр” гэж арилжаа хийгдсэний дараагийн арилжааны өдрийг;

2.1.11 “Төлбөр гүйцэтгэх” гэж энэхүү журамд заасны дагуу үнэт цаасны болон мөнгөн хөрөнгийн төлбөрийн гүйцэтгэлийг хангуулах;

2.1.12 “Төлбөрийн дагуу хийгдэх шилжүүлэг” (DVP) гэж зөвхөн мөнгөн төлбөр хийгдсэн нөхцөлд тухайн үнэт цаасны өмчлөх эрх шилжүүлэхийг;

2.1.13 “Төлбөрийн чадваргүй харилцагч” гэж төлбөр гүйцэтгэх өдөр Тооцооны байгууллагын тооцооны дансанд үнэт цаасны төлбөрийг 100 хувь байршуулаагүй этгээдийг;

2.1.14 “Барьцаа” гэж тооцооны гишүүнээс төлбөрийн үүргийн эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Тооцооны байгууллагын мөнгөн хөрөнгийн тусгай данс болон Төвлөрсөн хадгаламжийн байгууллага дах Тооцооны байгууллагын үнэт цаасны дансанд тус тус урьдчилан байршуулсан хөрөнгийг;

2.1.15 “Дэнчин” гэж арилжаанд оролцогчдын нөгөө талдаа төлбөл зохих төлбөрт оролцуулан урьдчилан өгсөн мөнгийг;

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТООЦООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧИД**

### **Гурав. Тооцооны үйл ажиллагаанд оролцогч, тооцооны гишүүд түүний эрх үүрэг**

3.1 Тооцооны үйл ажиллагаанд оролцогчид дараах этгээд хамаарна. Үүнд:

3.1.1 Тооцооны байгууллага

3.1.2 Төлбөр гүйцэтгэх банк

3.1.3 Тооцооны байгууллагын шууд гишүүн

3.1.4 Тооцооны байгууллагын ерөнхий гишүүн

3.1.5 Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага

### **3.2 Тооцооны байгууллага**

3.2.1 тооцооны байгууллага нь дэнчингийн тооцооллын үндсэн дээр эрсдлийг бууруулах зорилгоор тооцооны гишүүнээс барьцаа шаардах эрхтэй;

---

3.2.2 барьцаанд байршуулсан барьцааны хадгалалтад тооцооны байгууллага нь хариуцлага хүлээхгүй бөгөөд барьцааг гэрээний үндсэн дээр захиран зарцуулах эрхтэй.

3.2.3 тооцооны байгууллагаас тухай бүр тогтоож, Хороо зөвшөөрснөөр тооцооны үйл ажиллагаанд оролцогчдоос үйлчилгээний шимтгэл авах эрхтэй;

3.2.4 тооцооны үйл ажиллагааны журам, гэрээний хэрэгжилтийг хянах;

3.2.5 тооцооны байгууллага нь зөвшөөрөгдсөн гүйлгээний төлбөр тооцоог аюулгүй, найдвартай гүйцэтгэх үүрэгтэй.

3.2.6 Тооцооны байгууллага нь тооцооны гишүүдийн барьцаа хөрөнгийг тооцоолж, барьцаанд хүлээн зөвшөөрөгдөх үнэт цаасыг тодорхойлох, түүний өртөгийг тооцох үүрэгтэй;

3.2.7 үнэт цаасны арилжааны төлбөр гүйцэтгэх баталгааг хангаж, системийн эрсдлийг удирдах;

3.2.8 арилжааны тооцооллын үндсэн дээр гарсан төлбөрийн даалгаврыг цаг тухайд нь тооцооны гишүүдэд хүргэх;

3.2.9 үнэт цаасны болон мөнгөн хөрөнгийн төлбөр хугацаандаа хийгдэж байгаа эсэхэд хяналт тавих үүрэгтэй;

3.2.10 Тооцооны байгууллага нь шимтгэлийн хувийн талаарх мэдээлэл, түүний өөрчлөлтийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр мэдээлэх үүрэгтэй.

### **3.3 Төлбөр гүйцэтгэх банк**

3.3.1 төлбөр гүйцэтгэх банк нь үнэт цаасны арилжааны төлбөр гүйцэтгэхдээ энэхүү журмыг мөрдөх;

3.3.2 төлбөр гүйцэтгэх банк нь Тооцооны байгууллагатай харилцах албан тушаалтныг томилж, өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр Тооцооны байгууллагад албан бичгээр мэдэгдэх;

3.3.3 төлбөр гүйцэтгэх банк нь Тооцооны байгууллагаас ирүүлсэн төлбөрийн даалгаврыг үндэслэн цаг тухайд нь төлбөрийг гүйцэтгэх;

3.3.4 төлбөр гүйцэтгэх банк нь тооцооны байгууллагын данс дахь тооцооны гишүүдийн байршуулсан барьцаа хөрөнгийг бүрэн бүтэн найдвартай хадгалах үүрэгтэй бөгөөд тооцооны байгууллагын зөвшөөрөлгүй захиран зарцуулах эрхгүй;

3.3.5 төлбөрийн үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь Тооцооны байгууллагад үнэн зөв, саадгүй гаргаж өгөх;

3.3.6 төлбөр гүйцэтгэх банк нь үнэт цаасны төлбөр гүйцэтгэхтэй холбоотойгоор Тооцооны байгууллагаас ирүүлсэн мэдээллийг зөвхөн үнэт цаасны арилжааны төлбөр гүйцэтгэхэд ашиглах ба тухайн мэдээллийг бусдад тараах болон өөр зорилгоор ашиглахыг хориглоно.

3.3.7 Төлбөр гүйцэтгэх банк нь энэхүү журамд заасны дагуу үйлчилгээний шимтгэлийг төлнө.

3.3.8 Тооцооны байгууллагаас тухай бүр арилжааны төлбөрийн даалгаварын мэдээгээр хангуулах эрхтэй.

### **3.4 Тооцооны шууд гишүүн**

3.4.1 Тооцооны шууд гишүүн нь Тооцооны байгууллагаас үнэт цаасны арилжааны төлбөр тооцооны мэдээллийг цаг тухайд нь авах эрхтэй;

3.4.2 Арилжааны үнийн дүнгээс хамаарч дэнчин байршуулах дүнг өөрийн харилцагчдаас шаардах эрхтэй;

3.4.3 тооцооны шууд гишүүн нь Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагааны ерөнхий журам” –ын 6.6-д заасны дагуу барьцааг тооцооны байгууллагын барьцааны дансанд байршуулсан байх үүрэгтэй;

3.4.4 тооцооны шууд гишүүн нь өөрийн харилцагчдын төлбөрийн үүргийн хэрэгжилтийг бүрэн хангах үүрэгтэй;

3.4.5 тооцооны үйл ажиллагаанд шаардлагатай төлбөрийн мэдээллийг Тооцооны байгууллагад цаг тухайд нь үнэн зөв гаргах үүрэгтэй;

3.4.6 Тооцооны үйл ажиллагааны төлбөрийн эрсдлийг бууруулах зорилгоор байршуулсан барьцаа хөрөнгийг захиран зарцуулах эрхгүй;

### **3.5 Тооцооны ерөнхий гишүүн**

3.5.1 Тооцооны ерөнхий гишүүн нь арилжааны гишүүнчлэлгүй байх бөгөөд тооцооны эрхгүй бусад үнэт цаасны компанитай байгуулсан гэрээний дагуу тухайн ҮЦК-уудын хэлцлийн төлбөрийн үүргийг гүйцэтгэх эрхтэй;

3.5.2 Тооцооны байгууллагаас тооцооны үр дүнгийн мэдээллийг цаг хугацаанд нь авах эрхтэй.

3.5.3 Дэнчин, барьцааг Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагааны ерөнхий журам” –ын 6.6-д заасны дагуу байршуулах үүрэгтэй;

3.5.4 Тооцооны үйл ажиллагааны төлбөрийн эрсдлийг бууруулах зорилгоор байршуулсан барьцаа хөрөнгийг захиран зарцуулах эрхгүй;

3.5.5 Тооцооны үйл ажиллагаа хийхэд шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь Тооцооны байгууллагад гаргаж өгөх үүрэгтэй;

3.5.6 Тооцооны үйл ажиллагааг тасралтгүй, найдвартай гүйцэтгэх техник тоног төхөөрөмж, програм хангамжийг суурилуулсан байх үүрэгтэй.

3.5.7 тооцооны ерөнхий гишүүн нь өөрийн харилцагчдын төлбөрийн үүргийн хэрэгжилтийг бүрэн хангах үүрэгтэй;

### **3.6 Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага**

3.6.1 Тооцооны байгууллагаас хүлээн авсан үнэт цаасны төлбөрийн даалгаврын дагуу өмчлөх эрхийг цаг тухайд нь гүйцэтгэх үүрэгтэй;

3.6.2 Тооцооны байгууллагын үнэт цаасны барьцааны тусгай данс дахь хөрөнгийн хадгалалтын найдвартай байдлыг бүрэн хариуцах ба тооцооны байгууллагын зөвшөөрөлгүй тухайн дансыг захиран зарцуулах эрхгүй.

3.6.3 Тооцооны үйл ажиллагаанд шаардлагатай үнэт цаасны мэдээллийг цаг тухайд нь гаргаж өгөх үүрэгтэй.

3.6.4 Үнэт цаасны нийлүүлэлтийн дансны мэдээллийг Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны өмнөх өдөр Тооцооны байгууллагад хүргүүлэх үүрэгтэй.

3.6.5 Тооцооны байгууллагаас хүлээн авсан үнэт цаасны төлбөрийн даалгаврыг үндэслэн арилжаанд оролцох, үнэт цаасны аливаа шилжүүлэг хийх эрхийг хязгаарлан тусгаарлах гүйлгээг төлбөрийн даалгавар хүлээн авсан даруйд хийж гүйцэтгэх үүрэгтэй.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТООЦООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **Дөрөв. Хэлцэл баталгаажуулах, тооцоолол хийх**

4.1 Арилжаа эрхлэх байгууллагаас арилжааны хэлцлийг хүлээн авснаас хойш 1 цаг 20 минутын дотор тооцооны гишүүдтэй тооцооллын үр дүнг тулган баталгаажуулна.

4.2 ҮЦК нь харилцагчдаас авсан захиалгын дагуу төлбөрийн хуваарийн мэдээг арилжаа дууссанаас 1 цагийн дотор Тооцооны байгууллагад хүргүүлнэ.

4.3 Тооцооны байгууллага нь тооцооллын үр дүнг тулган баталгаажуулсны дараа төлбөрийн хуваарийг гарган тооцооны гишүүдэд хүргүүлж, арилжааны өдрийн 15:00 цагт төлбөрийн даалгаврыг төлбөр гүйцэтгэх банк болон төвлөрсөн хадгаламжийн төвд тус тус хүргүүлнэ.

4.4 Төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь үнэт цаасны төлбөрийн даалгавар хүлээн авсан даруйд худалдсан харилцагчийн үнэт цаасыг Төвлөрсөн хадгаламж дахь Тооцооны байгууллагын дансанд шилжүүлж, үнэт цаасыг төлбөр гүйцэтгэх хүртэл тусгаарлах гүйлгээг хийнэ.

### **Тав. Төлбөр гүйцэтгэх**

5.1 Төлбөр гүйцэтгэх банк нь үнэт цаасны төлбөр гүйцэтгэхтэй холбоотой харилцаанд зөвхөн Тооцооны байгууллагаас ирүүлсэн төлбөрийн мэдээнд үндэслэн төлбөрийг гүйцэтгэнэ.

5.2 Тооцооны байгууллага нь мөнгөн төлбөрийн даалгаврыг Төлбөр гүйцэтгэх банкинд, үнэт цаасны төлбөрийн даалгаврыг Төвлөрсөн хадгаламжийн төвд тус тус хүргүүлнэ.

5.3 Тооцооны ерөнхий болон шууд гишүүд нь Тооцооны байгууллагаас хүлээн авсан төлбөрийн даалгаврыг үндэслэн тухайн төлбөр гүйцэтгэх өдрийн 09:45 цагаас өмнө төлбөрийг гүйцэтгэнэ.

5.4 Тооцооны гишүүн нь өөрийн харилцагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр тухайн харилцагчийн арилжааны төлбөрийг зээлээр гүйцэтгэж болно.

5.5 Төлбөр гүйцэтгэх банк нь Төлбөр гүйцэтгэх банк дах Тооцооны байгууллагын дэнчингийн данснаас Тооцооны байгууллагын зөвшөөрөлгүй мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээ хийхийг хориглоно.

5.6 Тооцооны байгууллага нь Монголбанкны шаардлагыг хангахгүй болсон ТГБ-нд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

5.6.1 тухайн ТГБ-ны Тооцооны байгууллагаас зөвшөөрсөн төлбөрийн үйл ажиллагааг гүйцэтгэх эрхийг түдгэлзүүлэх;

5.6.2 Монголбанкны шаардлага хангахгүй болсон ТГБ нь Тооцооны байгууллагаас хүлээн авсан төлбөрийг төлөх үүргээс чөлөөлөгдөхгүй;

5.6.3 Тооцооны байгууллага нь энэ журмын 9.1-д заасан арга хэмжээний тухай мэдэгдлийг монгол, англи хэл дээр үйлдэж, арилжаа эрхлэх байгууллагатай хамтран олон нийтэд цахим хуудсаар мэдээлнэ.

5.7 Дээр дурьдсан эрхийг түдгэлзүүлэх арга хэмжээнээс үл хамааран ТГБ нь бусдад төлөх мөнгөн төлбөрийн үүргээ үргэлжлүүлэн биелүүлэх үүрэгтэй.

### **Зургаа. Мөнгөн хөрөнгийн төлбөрийг гүйцэтгэх**

6.1 Тооцооны байгууллагаас ирүүлэх төлбөрийн даалгаврын дагуу Төлбөр гүйцэтгэх банк нь Тооцооны байгууллагын дэнчингийн данснаас харилцагчдын төлбөрийн данс руу төлбөр авсан даруйд байршуулна.

6.2 Тооцооны байгууллага нь төлбөрийн хуваарийг төвлөрсөн хадгаламжийн байгууллагад Т+1 өдрийн 09:50 цагт хүргүүлснээр төлбөрийн мэдээлэл дуусгавар болох бөгөөд төлбөрийн үүргээ биелүүлээгүй тохиолдолд тооцооны байгууллага дах тухайн харилцагчийн Тооцооны гишүүний барьцаа хөрөнгөөс төлбөрийн үүргийг гүйцэтгүүлнэ.

6.3 Үнэт цаас худалдан авагч нь Төлбөр гүйцэтгэх банк дахь Тооцооны байгууллагын үнэт цаас худалдах, худалдан авах дэнчингийн дансанд үнэт цаасны төлбөрийн 50%-иас багагүй хэмжээний дэнчинг байршуулах ба энэ нөхцлийг хангасан харилцагчдын захиалгыг ҮЦК нь биелүүлэх үүрэг хүлээнэ.

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ДАНСНЫ УДИРДЛАГА**

#### **Долоо. Тооцооны байгууллага дахь дансны удирдлага**

7.1 Тооцооны байгууллага нь арилжааны хэлцлийн үр дүнд үнэт цаасны болон мөнгөн төлбөр тооцоо хийхэд шаардлагатай Тооцооны нэгдсэн данс (мөнгө, үнэт цаас, барьцаа хөрөнгө) –ыг хөтлөнө.

7.2 Тооцооны байгууллагын гишүүн нь өөрийн нэрээр Тооцооны байгууллагад Тооцооны нэгдсэн данс нээлгэх бөгөөд дансны бүртгэлийг Тооцооны байгууллага үнэн зөв хөтлөнө.

## **ТАВДУГААР БҮЛЭГ. ЭРСДЛИЙН УДИРДЛАГА**

### **Найм. Эрсдлийн удирдлага**

8.1 Тооцооны байгууллага нь төлбөр тооцооны системд оролцогчдод учрах эрсдлийг бууруулж, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн дор дурьдсан эх үүсвэрийг зохих журмын дагуу захиран зарцуулах замаар төлбөр тооцооны эрсдлийг удирдана. Үүнд:

8.1.1 Дэнчин

8.1.2 Барьцаа

8.1.3 Төлбөрийн баталгааны сан

8.2 Тооцооны байгууллагын төлбөр тооцооны эрсдлийн удирдлагыг “Тооцооны байгууллагын гишүүдийн төлбөрийн чадварын эрсдлийг удирдах, зохицуулах журам”-д зааснаар зохицуулалтыг хэрэгжүүлнэ.

### **Ес. Хариуцлага**

9.1 ҮЦК болон Төлбөр гүйцэтгэх банк нь энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд тухайн зөрчил болон өмнө нь гаргаж байсан бусад зөрчлийн ноцтой байдлыг харгалзан Тооцооны байгууллагаас дор дурдсан арга хэмжээг авна:

9.1.1 албан шаардлага бичгээр хүргүүлнэ.

9.1.2 хэрэв өмнө нь тухайн төрлийн зөрчил гаргаж, Тооцооны байгууллагаас албан шаардлага бичгээр хүргүүлж байсан тохиолдолд Тооцооны байгууллагын системд орох эрхийг түр зогсооно.

9.1.3 талуудын хооронд байгуулсан гэрээг цуцална.

9.2 Тооцооны байгууллагын гишүүд энэхүү журмыг зөрчсөн үйлдэл нь харилцагч болон бусад мэргэжлийн байгууллагад хохирол учруулсан тохиолдолд Санхүүгийн зохицуулах хороо болон хуулийн байгууллагад хандан шийдвэрлүүлнэ.

9.3 Төлбөр гүйцэтгэх банк болон ҮЦК-ийн Тооцооны байгууллагын системд оролцох эрхийг түдгэлзүүлсэн тохиолдолд тэдгээр нь зөвхөн бусад Төлбөр гүйцэтгэх банк, ҮЦК болон харилцагчийн эрх ашгийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай гүйлгээг хийнэ.

---

## Хавсралт 1

### Үйлчилгээний шимтгэл

Д/д	Тооцооны байгууллагын шимтгэлийн төрөл	Дүн	
1	Гүйлгээ тутамд	500	